# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 08 өдөр Дугаар А/214 Улаанбаатар хот

## Төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүр гаргаж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газар /Р.Ганхуяг/-т даалгасугай.

3. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Л.Лувсан/-т даалгасугай.

ДАРГА Ц.ГАНХҮҮ

5128921 1117149041

0801700739

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын
даргын 2017 оны 09 дугаар сарын 08-ны
өдрийн А/214 дугаар тушаалын хавсралт

# ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН “АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт | Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа | Хүрэх түвшин, үр дүн | Хариуцах нэгж болон хамтран ажиллах байгууллага |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх | ГЗБГЗЗГ-аас үзүүлдэг төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой үйлчилгээний жагсаалт, судалгаа гаргах | 2017-2018 | Цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой үйлчилгээний жагсаалт гарсан, шийдвэрлэх арга зам тодорхойлсон байна. | ОЗМТХ бусад нэгжтэй хамтран |
| | | Байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хүлээн авах, шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх, сайжруулах | 2017-2018 | Иргэдийн өргөдөл, гомдол шуурхай шийдвэрлэгдэж хэвшсэн байна. | ЗУХАГ |
| | | Орон нутгийн харьяа байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тэдгээрийн үйл ажиллагааны шударга, ил тод, нээлттэй байдлын талаар судалгаа хийх, үр дүнг танилцуулах | 2017-2018 | Хяналт-шинжилгээ, үнэлгээ үр дүнтэй хийгдсэн, судалгаа гарсан байна. | ЗУХАГ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хяналт-шинжилгээ, үнэлгээний мөрөөр авсан арга хэмжээ /дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал/-ний үр дүнгийн талаар мэдээлсэн байх | 2017-2018 | Арга хэмжээг мэдээлсэн байна. | ЗУХАГ бусад нэгжүүдтэй хамтран |
| 2 | Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх | Шилэн дансны цахим хуудсанд www.shilendans.gov.mn холбогдох мэдээллээ тогтмол оруулах | 2017-2020 | Мэдээлэл тогтмол орсон байна. | ЗУХАГ, СЭЗХ |
| | | Төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хадгалалт, зарцуулалтын байдалд хяналт тавих | 2017-2020 | Санхүүгийн хариуцлагыг дээшлүүлэх арга замыг тодорхойлж, хэрэгжүүлсэн байна. | СЭЗХ |
| 3 | Худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал болон хяналтыг нэмэгдүүлэх | Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас болон шилэн дансны цахим хуудсаар олон нийтэд нээлттэй танилцуулах | 2017-2020 | Төлөвлөгөө ил тод нийтлэгдсэн байна. | ЗУХАГ, СЭЗХ |
| | | Тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах | 2017-2020 | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Бүх нэгжүүд |
| | | Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх | 2017-2020 | Төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангасан байна. | Бүх нэгжүүд |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх | Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан дүгнэлтийг үндэслэн томилгоо хийх | 2017-2020 | Хууль тогтоомжид нийцсэн байна. | ЗУХАГ |
| | | Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох асуудлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах | 2017-2020 | Хууль тогтоомжид нийцсэн байна | ЗУХАГ |
| | | ГЗБГЗЗГ-ын албан хаагчийн Ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулах, албан хаагчдад танилцуулах, мөрдүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах | 2017 | Ёс зүйн дүрэм дагаж мөрдөгдсөн байна | ЗУХАГ |
| | | Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг албан хаагчдад сурталчлах, сургалт зохион байгуулах | 2017-2020 | Албан хаагчид сургалтад хамрагдсан байна. | ЗУХАГ, АТГ |
| | | Төрийн албан хаагчдын мэргэшсэн, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр, төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлах | 2019 | Төрийн албан хаагчийн мэргэшсэн, тогтвортой байдал хангагдсан байна. | ЗУХАГ |
| | | Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг бүрдүүлсэн байх | 2017-2020 | Шийдвэр ил тод, нээлттэй байх нөхцөл, боломж бүрдсэн байна. | ЗУХАГ бусад нэгжүүдтэй хамтран |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачлагыг дэмжих | Бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд салбарын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах, тэдний оролцоог дэмжих | 2017-2020 | Төрийн бус байгууллагын оролцоог хангасан байна. | Бүх нэгжүүд |
| | | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой эсэх талаар судлах, хэрэгжүүлэх | 2017-2018 | ТББ-аар гүйцэтгүүлэх боломжтой төрийн үйлчилгээний жагсаалт гарсан байна. | Бүх нэгжүүд |

____оОо___